# Дээд боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх стандартууд

Sc.D., профессор С.Батхуяг
МУБИС-ийн БСАЗ-н тэнхмийн зөвлөх профессор,
ДБСМН-ийн ерөнхийлөгч
e-mail: batkhuyag_s@yahoo.com;
phone: 99154618;  98154618

# Боловсролын стандарт

- Стандартын төрөл, шинж:
  - Бүтээгдэхүүний стандарт – эталончилсан
  - Үйлчилгээний стандарт - зөвлөмжилсөн
- Боловсролын стандарт – боловсролын үйлчилгээнийн чанарын баталгааг хангахад чиглэсэн наад захын шаардлагыг тодорхойлсон зөвлөмжлөх шинжтэй баримт бичиг

# Боловсролын байгууллагын стандарт

- Байгууллага – нийгмийн харилцаанд тодорхой үүрэг гүйцэтгэхээр удирдлага, зохион байгуулалтад орсон ***хамт олон, тэдний үйл ажиллагааны нэгдэл***
- Байгууллагын стандарт – тухайн хамт олны удирдлага, зохион байгуулалт болоод үйл ажиллагаанд тавих наад захын шаардлагуудын тогтолцоо

# Дээд боловсролын сургалтын байгууллага

- Сургалт – боловсролын үйлчилгээг олон түмэнд хүргэх үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр
- Сургалтын байгууллага – боловсролын үйлчилгээг олон түмэнд хүргэх үндсэн үүрэг бүхий нийгмийн институт

# Дээд боловсролын сургалтын байгууллагын стандарт

- Дээд боловсролын сургалтын байгууллагын стандарт – тухайн хамт олны удирдлага, зохион байгуулалт болоод үйл ажиллагаанд ***мэргэжлийн дээд боловсролын чанартай, баталгаатай үйлчилгээ үзүүлэхэд тавигдах наад захын шаардлагуудын тогтолцоо***

# Сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх стандарт

- Магадлан итгэмжлэх стандарт – магадлан итгэмжлэгдэхэд тавигдах наад захын шаардлага
- Сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх стандарт – тухайн байгууллагын зорилтот үйлчилгээгээ эрхлэхийн тулд хангасан байх наад захын шаардлагын тогтолцоог тодорхойлсон баримт бичиг

# Сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх стандарт (үргэлжлэл)

- Зориулалт:
  - Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа явуулах эрхийг баталгаажуулахад тулгуур болгох баримт бичиг
  - Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээ хийж, ажлынхаа доголдож байгаа талыг илрүүлэн засан сайжруулж ажиллахад тулгуурлах баримт бичиг

# Сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх стандарт (үргэлжлэл)

- Бүтэц:

| Фаз | Стандарт | Шалгуур | Нотолгоо |
|---|---|---|---|
| Орц | 5 | 30 | 72 |
| Үйл явц | 4 | 21 | 63 |
| Үр нөлөө | 1 | 7 | 11 |
| Бүгд | 10 | 58 | 146 |

# Стандартын шалгуур, нотолгоо

- Стандартын шалгуур – тухайн шаардлагын хэрэгжилтийн илрэл
- Нотолгоо – шаардлагын хэрэгжилтийн байдлыг батлах баримт

# Стандартын шалгуур, нотолгоо
(үргэлжлэл)

- Стандарт 1. ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТ
  - Сургууль нь эрхэм зорилго, зорилтуудыг дээд боловсролын хөгжлийн олон улсын чиг хандлага болоод өөрийн сургуулийн онцлогт нийцүүлэн тодорхойлж, баталгаажуулан, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлж дүгнэхэд тууштай баримтлахын баримталж ажиллахын зэрэгцээ тодорхой хугацаанд хянан үзэж, шинэчилдэг байна.

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 1.1 | Эрхэм зорилго<br><br>Эрхэм зорилго нь сургуулийн өвөрмөц дүр төрх, үйл ажиллагааны хэтийн төлөв,тэмүүллийг тусгасан байна. | - Сургуулийн өвөрмөц байдал, хэтийн төлвийн давуу талаа тусгасан байдал<br><br>- Гадаад ба дотоод оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа байдал |
| 1.2 | Үзэл баримтлал<br><br>Сургуулийн үзэл баримтлалд тусгагдсан үнэт зүйлс, хандлага, үйл ажиллагааны үндсэн зарчмууд нь бүх салбар, нэгжийн  үйл ажиллагаанд тууштай хэрэгждэг байна. | - Сургуулийн үзэл баримтлал нь Монгол улсын хөгжлийн болон боловсролын үзэл баримтлалд нийцсэн байдал<br><br>- Сургууль, салбар, нэгжүүдийн бодлого, эрх зүйн бичиг баримтуудад үзэл баримтлалын үзэл санаа тусгагдсан байдал |

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 1.3 | Зорилго, зорилтууд<br><br>Сургуулийн үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг бодитой, хэрэгжихүйц байдлаар тодорхойлж, хэрэгжилтийг тасралтгүй хянан үнэлж, сайжруулдаг байна. | - Гадаад дотоод хүчин зүйлсийн дүн шинжилгээний чанар, үр өгөөжийн түвшин<br><br>- Зорилго, зорилтуудын хэрэгжилтийн үнэлэгдэх боломжийн байдал<br><br>- Сургуулийн дотоод хяналт-шинжилэгээ, үнэлгээний тогтолцооны төлөвшлийн түвшин |
| 1.4 | Үйл ажиллагааны зорилго, зорилтууд болон тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үнэлгээ, дүгнэлтийг олон нийтэд ил тод мэдээлж, хамт олны оролцоотойгоор шинэчлэн тодорхойлдог байна. | - Үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэдэг тогтолцоо төлөвшсөн байдал<br><br>- Үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг тодорхойлоход хамт олны оролцооны түвшин |

# Стандартын шалгуур, нотолгоо
(үргэлжлэл)

- Стандарт 2. ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВЛӨЛТ
  - Сургууль, түүний салбар, нэгжүүд нь үйл ажиллагааны болон төсвийн урт, богино хугацааны төлөвлөгөөтэй ажиллаж, гүйцэтгэл, үр дүнд нь байнгын дүн шинжилгээ хийж, үр нөлөөг нь дээшлүүлдэг байна.

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 2.1 | Төлөвлөлт, төсөвлөлт<br><br>Үйл ажиллагааны төлөвлөлтийг төсөвлөлттэй уялдуулан системтэйгээр хэрэгжүүлдэг тогтолцоог бүрдүүлсэн байна. | - Жил, жилийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээний чанар, үр дүн<br><br>- Төлөвлөлтийн тогтолцооны уян хатан чанарын түвшин<br><br>- Төлөвлөлт, төсөвлөлтөнд гарсан ахиц, дэвшил |
| 2.2 | Үр дүнгийн тайлан, мэдээ<br><br>Сургууль, салбар, нэгжийн түвшин бүрт төлөвлөгөө, төсвийн хэрэгжилтийг гүйцэтгэлийн үр дүнгийн тодорхой шалгуур, үзүүлэлтүүдээр гаргадаг байна. | - Тайлагналтын тогтолцооны төлөвшсөн байдал<br><br>- Шалгуур, үзүүлэлтүүдийн оновчтой байдал<br><br>- Шилэн дансны хэрэгжилтийн түвшин байдал |

# Стандартын шалгуур, нотолгоо
(үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 2.3 | Чанарын удирдлагын тогтолцоо<br><br>Сургуулийн дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний  үйл ажиллагаа нь салбар, нэгж болон багш, ажилтнуудын бие даасан байдал, академик эрх чөлөөгөө ханган ажиллахад нь дэмжлэг үзүүлж,  улмаар сургалтын чанарын баталгааг хангахад чиглэсэн байна. | - Чанарын удирдлагын тогтолцооны төлөвшлийн түвшин, үйл ажиллагааны чиг зорилгын хандлагын шинж<br><br>- Үйл ажиллагааны тогтворжил, үр өгөөжийн байдал<br><br>- Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар хамт олны сэтгэл ханамжийн байдал |

# Стандартын шалгуур, нотолгоо
(үргэлжлэл)

- Стандарт 3. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
  - Сургууль нь хүмүүнлэг, ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн бүтэц, зохион байгуулалт, засаглал, эрх зүйн зохицуулалтаар дамжуулан үйл ажиллагааныхаа чанар, үр өгөөжтэй байх нөхцлийг хангадаг байна.

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 3.1 | Зохион байгуулалт<br><br>Сургуулийн бүтэц, салбар, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо, эрх мэдэл, үүрэг хариуцлагын хуваарилалт, зохион байгуулалт нь хамт олон болон хувь хүмүүсийн идэвх санаачлагатай, бүтээлч, хариуцлагатай ажиллах нөхцөл, боломжийг хангасан байна. | - Сургуулийн бүтцийн оновчтой байдал<br><br>- Сургуулийн дотоод дүрэм, журмуудын боловсруулалт, агуулга, үйл ажиллагааны зохицуулалтын арга механизмын ерөнхий шинж байдал |
| 3.2 | Засаглал<br><br>Сургуулийн удирдлагын бүх шатанд шийдвэр гаргах, түүний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх үйл ажиллагаанд,багш, суралцагчдын шууд болон шууд бусаар оролцох боломж бүрдсэн байна. | - Сургуулийн болон салбар, нэгжийн дотоод дүрэм, журмуудад шийдвэр гаргах болон үнэлж дүгнэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцооны механизмыг тусгасан байдал<br><br>- Бүх шатны үйл ажиллагааны ил тод байдлын талаарх олон нийтийн сэтгэл ханамжийн байдал |

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 3.3 | Захиргаа<br><br>Сургуулийн захиргаа нь өөрийн хамт олны үндсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд ажиллах боловсон хүчин, материаллаг болон санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилан, үр ашигтай зарцуулах ажлыг зохион байгуулж, өдөр тутмын үйл ажиллагааны хэрэгжилт, чанарыг хариуцан ажилладаг байна. | - Захиргааны удирдлагын бүтэц, бүрэлдэхүүний төлөөллийн оновчтой байдал<br>- Шийдвэр гаргах үйл ажиллагаанд баримталдаг үндсэн зарчмын шинж<br>- Тайлан, тайлагналтын механизмын шинж<br>- Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн дүн шинжилгээний чанар, үр өгөөж<br>- Сургуулийн үйл ажиллагаанд гарч буй ахиц, өөрчлөлт |
| 3.4 | Хамтын ажиллагаа<br><br>Сургууль нь өөрийн эрхэм зорилго, чиг үүрэгтэй төсөөтэй үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааны сүлжээтэй байж өөрийн бүх талын үйл ажиллагаанд дэмжлэг авахын зэрэгцээ нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлдэг байна. | - Хамтын ажиллагааны сүлжээний цар хүрээ, үйл ажиллагааны үр өгөөж, арга туршлага |

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 3.5 | Олон нийтийн байгууллага<br><br>Сургуулийн захиргаа нь өөрийн сургууль дээрх олон нийтийн байгууллагуудаар дамжуулан багш, ажилтан, суралцагчдын бодлого боловсруулах, шийдвэр гаргах, чанарыг үнэлэхэд оролцоог дэмжин ажиллана. | - Сургуулийн олон нийтийн байгууллагуудын ажлын арга туршлага, уялдаа, үр өгөөж |
| 3.6 | Удирдлагын мэдээллийн систем<br><br>Сургууль нь орчин үеийн мэдээлэл, харилцааны технологид суурилсан удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлэн, үр ашигтай ажиллуулж, байнга боловсронгуй болгон хөгжүүлдэг байна. | - УМС-ийн төлөвшил, ажлын хэрэгцээ хангалтын түвшин<br><br>- Бусад бүртгэл мэдээллийн системтэй холбогдсон байдал<br><br>- УМС-ийн талаар хамт олон болон олон нийтийн сэтгэл ханамж |

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 3.7 | Эрх зүйн зохицуулалт<br><br>Сургууль нь нэгж, хамт олон, хувь хүн бүрийн оюуны болон академик эрх чөлөөг хангасан, хүмүүнлэг, ардчилсан нийгмийн харилцааны хэм хэмжээ, мэргэжлийн ёс зүйд тулгуурласан, боловсрол, сургалтын үйл явцын шинжлэх ухааны үндэслэлтэй хэм хэмжээ, өдөр тутмын үйл ажиллагааны хариуцлага, сахилгын горимыг тогтоон тодорхойлсон эрх зүйн зохицуулалтын тогтолцоог бүрдүүлж, мөрдөхийн зэрэгцээ, нээлттэй хянан сайжруулдаг байна. | - Зайлшгүй байх бодлого, эрх зүйн баримт бичгүүдийн бүрдэл, боловсруулалтын чанар<br>- Эрх зүйн баримт бичгүүд болон холбогдох мэдээллийг нийтийн хүртээл болгодог тогтолцооны бүрдэл, үйл ажиллагааны тогтворжилт<br>- Эрх зүйн зохицуулалтанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцооны төлөвшил<br>- Сургуулийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад олон нийтийн оролцоо ба сэтгэл ханамжийн байдал |

# Стандартын шалгуур, нотолгоо
(үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 3.8 | Чанарын дотоод үнэлгээ, баталгаажилт<br><br>Сургуулийн салбар, нэгж, бүр өөрийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах дотоод хяналт-шинжилгээний тогтолцоотой, удирдлага болон хүний нөөц, санхүү, материаллаг нөхцлийг бүрдүүлсэн байна. | - Дотоод хяналт-шинжилгээний тогтолцоо үйл явц нь бүгдэд ил тод, ойлгомжтой байдал<br><br>- Дотоод хяналт-шинжилгээний тогтолцоо нь тогтвортой, үр дүнтэй ажилладаг байдал |
| 3.9 | Чанарын хөндлөнгийн үнэлгээ, баталгаажилт<br><br>Өөрийн санаачлагаар эрх бүхий, мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэдэг байна. | - Үнэлгээ, магадлан итгэмжлэлийн үр дүн<br><br>- Байгууллага, хамт олны үйл ажиллагаанд гарсан ахиц, өөрчлөлт |

# Стандартын шалгуур, нотолгоо
(үргэлжлэл)

- Стандарт 4. ХҮНИЙ НӨӨЦ
  - Сургууль нь өөрийн эрхэм зорилго болон үйл ажиллагааныхаа зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах ажиллах боловсон хүчин,  хүний нөөцийг салбар, нэгж, хөтөлбөр бүрээр төлөвлөн тооцоолж, бүрдүүлэн ажиллуулахын зэрэгцээ тэдний байнгын хөгжлийг дэмждэг байна.

# Стандартын шалгуур, нотолгоо
(үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 4.1 | Хүний нөөцийн бодлого, зохицуулалт<br><br>Сургууль нь өөрийн байгууллагын хүний нөөцийн тооцоо, төлөвлөлт, ханган нийлүүлэлт, хөгжлийн талаар баримтлах бодлого, дүрэм, журамтай, түүнийг байнга сайжруулан мөрддөг байна. | - Хүний нөөцийн бодлого, зохицуулалттай холбогдох баримт бичгийн бүрдэл, мөрдөлтийн байдал |
| 4.2 | Хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн сан<br><br>Сургууль нь хүний нөөцийн бүрдэл, шилжилт хөдөлгөөн, нөөцийн нөхөн хангалтын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, ашигладаг байна. | - Хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл, ашиглалтын түвшин<br><br>- Хүний нөөцийн төлөвлөлтийн чанар, ханган нийлүүлэлтийн түвшин |

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 4.3 | Багш, ажилтны хөгжил<br><br>Сургууль нь салбар, нэгж, хөтөлбөр бүрээр багш, ажилтны зохистой орон тоо, ур чадварын шаардлагыг тогтоон, нээлттэй сонгон шалгаруулж, ажлын байрандаа хөгжих үйл явцыг дэмждэг байна. | - Салбар, нэгжүүдийн хүний нөөцийн бүрдлийн түвшин<br><br>- Сонгон шалгаруулах тогтолцооны чанар<br><br>- Багш, судлаач бүр өөрийн хөгжлийн хөтөлбөртэй эсэх<br>- Шинэ, залуу багш нар болон судлаачдыг дэмжих үйл ажиллагааны чанар, үр өгөөжийн түвшин |
| 4.4 | Багш, ажилтны цалин хөлс, урамшуулал<br><br>Багш, ажилтны ажлын нөхцөл, цалин хөлс, урамшуулал, дэмжлэг нь тэдний ажлын гүйцэтгэл, чанарт үндэслэсэн шударга, эрх тэгш, уян хатан хэрэгжих тогтолцоо бүрдсэн байх ба цаг үеийн шаардлагад тулгуурлан шинэчлэгддэг байна. | - Цалингийн түвшин, шинэчлэлийн тогтолцооны уян хатан чанар<br><br>- Багш, ажилтны ажлын гүйцэтгэлийн соёл ба чанарын үнэлгээний тогтолцоо<br><br>- Урамшуулал, дэмжлэгийнтогтолцооны үр өгөөж<br><br>- Хамт олны сэтгэл ханамжийн түвшин |

# Стандартын шалгуур, нотолгоо
(үргэлжлэл)

- Стандарт 5. МАТЕРИАЛЛАГ болон ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ
  - Сургууль нь  эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилго, зорилтуудаа үр дүнтэй хэрэгжүүлэхнд шаардлагатай материаллаг болон технологийн нөхцөлийг хангалттай бүрдүүлж, тасралтгүй сайжруулан бэхжүүлэх бодлого, зохицуулалттай байна.

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 5.1 | Материаллаг нөхцөл<br><br>Сургуулийн барилга, байгууламж, хичээлийн анги танхим нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хэм хэмжээнд нийцсэн, хүчин чадал нь сургалтын үйл ажиллагаанд хангалттай хүрэлцээтэй байх ба сурах, сургах үйл явцыг дэмжих орчин бүрдүүлсэн байна. | - Сургуулийн материаллаг нөхцөл байдлын одоогийн болон ирээдүйн хүчин чадлын тооцооны бүрдэл, чанар<br><br>- Сургалтын орчныг хөгжүүлэх төлөвлөгөө, төсвийн тооцооны чанар, хэрэгжилтийн түвшин<br><br>- Багш, суралцагчдын сэтгэл ханамжийн түвшин |
| 5.2 | Технологийн нөхцөл<br><br>Сургалт, судалгааны лаборатори, техник технологийн нөөц, хангамж нь багш суралцагчдын хэрэгцээ, сургалтын хөтөлбөрийн болон эрдэм судлалын ажлын үр дүн, чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн байна. | - Сургалт болон судалгааны лаборатори, техник технологийн хүрэлцээ, хангамж, шинэчлэлийн ажлын шаардлага хангалтын түвшин<br><br>- Сургууль болон салбар дундын судалгааны хамтарсан лаборатори ашиглалтын байдал<br><br>- Зайн сургалтын тогтолцооны төлөвшлийн байдал |

# Стандартын шалгуур, нотолгоо
(үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 5.3 | Сургалт, судалгааны тусгай зориулалттай програм хангамжууд, тэдгээрийг ашиглахад хүрэлцээтэй хүчин чадал бүхий компьютер, нэмэлт төхөөрөмжүүдээр хангагдсан байна. | - Тусгай зориулалтын программ хангамжуудын чанар, түвшин<br>- Компьютер,нэмэлт төхөөрөмжүүдийн хүчин чадал, ашиглалтын судалгаа |
| 5.4 | Багш, ажилтан, суралцагчдын мэдээлэл солилцох харилцаа, холбоо, мэдээллийн технологийн таатай орчин бүрдүүлсэн байна | - Дотоод сүлжээний үйл ажиллагааны тогтворжил, чанар<br>- Интернетийн орчны чанар<br>- Олон нийтийн сүлжээ ашиглах нөхцөл боломжийн бүрдэлийн байдал |

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 5.5 | Номын сан<br><br>“Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага /MNS5742:2007/-ыг хангасан байхын зэрэгцээ олон улсын түвшинд хүрэхийг зорьж ажилладаг байна. | - Номын сангийн удирдлага, зохион байгуулалтын чанарын түвшин<br><br>- Номын сангийн мэдээллийн сангийн төлөвлөлт, төсөвлөлт, шинэчлэл, ханган нийлүүлэлтийн түвшин |
| 5.6 | Цахим сан хөмрөгийг байнга нэмэгдүүлэн дижитал номын сангийн шинэ техник, технологийг үйлчилгээндээ нэвтрүүлж, мэдээллийн эх үүсвэр харилцан солилцдог байна. | - Номын сангийн программ хангамжийн ашиглалтын түвшин<br><br>- Цахим сан хөмрөгийн баяжилт, ашиглалтын түвшин<br><br>- Дижитал номын сан бүрдлийн байдал |
| 5.7 | Олон улсын мэдээллийн сүлжээ, нээлттэй эх үүсвэрүүдийг сургалт, судалгаандаа ашиглах боломж, нөхцөлийг байнга нэмэгдүүлдэг байна. | - Номын сангийн олон улсын сүлжээнд нэгдсэн байдал<br><br>- Нээллтэй эх үүсвэрүүдийн ашиглалт |

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 5.8 | Санхүүгийн нөөц<br><br>Сургууль, салбар нь сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагааны чанарыг хангахад хүрэлцээтэй санхүүгийн найдвартай эх үүсвэр, нөөцийг төлөвлөж бүрдүүлдэг байна. | - Сургуулийн санхүүгийн орлого, зарлагын шинжилгээний чанар, үр ашгийн түвшин<br><br>- Сургалтын хөтөлбөрүүдийн төсвийн төлөвлөлт, хүрэлцээний түвшин<br>- Оюутны төлбөрийн тооцоо, төлөвлөлт, төлөлтийн түвшинг дээшлүүлэх талаар авч байгаа арга хэмжээ, түүний үр өгөөж |
| 5.9 | Санхүүгийн тогтвортой байдлыг ханган гэнэтийн үүсэх нөхцөл байдлыг шийдвэрлэх нөөц боломжийг бүрдүүлсэн байна. | - Эрсдлийн шинжилгээний түвшин, чанар |
| 5.10 | Санхүү, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн программ хангамж ашиглан, ил тод тайлагнал, мэдээллийн тогтолцоог бүрдүүлсэн байна. | - НББ-ийн тогтолцооны техник, программ хангамжийн түвшин<br><br>- Шилэн дансны хуулийг хэрэгжүүлтийн түвшин |

# Стандартын шалгуур, нотолгоо
(үргэлжлэл)

- Стандарт 6. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ШИНЭЧЛЭЛ
  - Сургууль нь  үндэсний болон олон улсын зах зээлийн бодит эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, олон улсын жишигт нийцэхүйц боловсролын чанартай үйлчилгээ үзүүлдэг байна.

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 6.1 | Хөтөлбөрийн хороо<br><br>Сургууль нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх явц, үр дүнг хянах, үнэлэх, чанарыг баталгаажуулах бодлого, эрх зүйн зохицуулалтыг хариуцсан хороодыг байгуулж хөтөлбөрийн багуудын ажлын уялдааг хангаж, удирдан зохион байгуулдаг байна. | - Хөтөлбөрийн хороодын бүтэц, зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийн оновчтой байдал<br><br>- Бодлого, эрх зүйн бичиг баримтуудын чанар, хэрэгжилтийн түвшин<br><br>- Хөтөлбөрийн баг, зохицуулагчдын чиг үүргийн оновч, хэрэгжилтийн түвшин<br><br>- Хөтөлбөрийн чанарын үнэлгээ, дотоод баталгаажуулалтын тогтолцооны төлөвшил, үйл ажиллагааны үр дүнгийн түвшин |
| 6.2 | Хөтөлбөрийн зорилго<br><br>Сургалтын хөтөлбөрүүд нь суралцагчид үндэсний болоод олон улсын стандартад нийцсэн боловсрол эзэмших, бүтээлч сэтгэлгээтэй, хариуцлагатай, насан туршдаа суралцан хөрвөх чадвартай мэргэжилтэн болж төлөвшихөд чиглэсэн цогц үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн байна. | - Төгсөгч-мэргэжилтний загварын тодорхойлолтын түвшин, чанар<br><br>- Хөтөлбөрийн зориулалт, зорилго, зорилтуудыг тодорхойлсон сургалтын онолын үзэл баримтлалын чиг хандлага<br><br>- Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, чадамж, хандлага төлөвшлийн түвшний үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байдал. |

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 6.3 | Хөтөлбөрийн агуулга, арга зүй<br><br>Сургалтын хөтөлбөрүүдийн агуулга, хэрэгжүүлэх арга зүй нь суралцагчид хувийн онцлог шинж, хэрэгцээ шаардлага, нөхцөл боломждоо нийцүүлэн сонголт хийх бололцоог хангасан олон хувилбартай, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц байна. | - Хөтөлбөрүүдийн ерөнхий бүтэц, боловсруулалтын түвшин, чанар<br><br>- Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаарх олон нийтийн үнэлгээний түвшин<br><br>- Хөтөлбөрүүдээ магадлан итгэмжлүүлсэн байдал |
| 6.4 | Сургалтын технологи<br><br>Сургалтын технологи нь суралцагчдын суралцах үйлийг тэдний бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан, сурч боловсрохын зүй тогтлын дагуу зохион байгуулах, бие даан ажиллах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн байна. | - Багш нарын сургалтын үйл явцыг төлөвлөж байгаа хандлага, байр суурь<br><br>- Суралцагчдын сургалтын үйл явцад оролцож байгаа байдал, хандлага<br><br>- Суралцагчийн бие даан суралцах чадварын төлөвшлийн түвшин<br><br>- Багш, суралцагчдын мэдээллийн технологи ашиглах боломжийн талаарх сэтгэл ханамжийн түвшин |

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 6.5 | Сургалтын орчин<br><br>Сургалтын орчин нь хөтөлбөрийн явцад багш, суралцагчид мэдээ, мэдээллийн эх сурвалжийг нээлттэй ашиглах, ажил мэргэжлийн ур чадвар эзэмшихэд зайлшгүй шаардлагатай орчин, нөхцөлийг хангалттай бүрдүүлдэг байна. | - Хөтөлбөрийн явцад зайлшгүй шаардагдах сурах бичиг, ном гарын авлагын фонд бүрдүүлэлт, ашиглах боломжийн түвшин<br>- Цахим эх сурвалжийн хүртээмж<br>- Мэдээллийн сүлжээ ашиглах боломж<br>- Лаборатори, техник хангамжийн түвшин<br>- Виртуал сургалтын орчинг бүрдүүдсэн байдал |
| 6.6 | Хөтөлбөрийн үнэлгээ<br><br>Хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явц-үр дүнд суурилсан чанарын үнэлгээг сургуулийн удирдлага,мэргэжлийн баг, багш нар хамтран хийдэг байна. | - Хөтөлбөрийн үнэлгээний шалгуур, арга, аргачлал нь сургалтын үр дүн, суралцагчдын сурах болон багш нарын сургах арга барилыг сайжруулахад чиглэсэн байдал<br>- Үнэлгээний үр дүнд тулгуурлан хөтөлбөрийг сайжруулан хэрэгжүүлж ирсэн байдал<br>- Мэргэжлийн баг болон багш нарын өөрийн үнэлгээний арга баоил эзэмшсэн байдал |

# Стандартын шалгуур, нотолгоо
## (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| 6.7 | Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажилт<br><br>Хэрэгжүүлж буй бүх хөтөлбөртөө үечилсан байдлаар, тодорхой давтамжтайгаар үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулах бодлого, журмыг хэрэгжүүлж, сургалтын үр дүнг жигд, өндөр түвшинд хангах тогтолцоотой байна. | - Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажууллын тогтолцоо<br><br>- Сургалтын үр дүнгийн ахиц, ололт<br><br>- Багш, суралцагчдын оролцооны түвшин |
| 6.8 | Сургалтын бусад үйл ажиллагаа<br><br>Сургууль нь сургалтын үндсэн хөтөлбөр болон албан бус сургалтыг нийгмийн болоод хувь хүмүүсийн хэрэгцээ, шаардлагатай уялдуулан олон хувилбартай агуулга, арга хэлбэрээр зохион байгуулж үйлчилгээний хүрээг тэлэхээс гадна нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ | - Үндсэн хөтөлбөрөөр зохион байгуулж буй танхимаас гадуурх сургалтын төрөл, хэлбэр, чанар, үр дүн<br><br>- Сертификат, үнэмлэх олгох сургалтын төрөл, тоо, чанар<br><br>- Зайн болон виртуал сургалтуудын чиглэл, хүрээ, хамралт, чанар<br><br>- Мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтарсан дадлага, туршилт судалгаа гэх мэт<br><br>- Мэргэшүүлэх сургалтын чиглэл, тоо, чанар |

Анхаарал хандуулсанд баярлалаа.